



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 14 (151)

Монгол Улсын Засгийн газрын 2000 оны
24 дүгээр тогтоолын хавсралт:

- Монгол Улсын Төрийн ёслолын журам
Монгол Улсын Дээд шүүхийн тогтоол:
- Хоршиооны тухай Монгол Улсын хуулийн зарим зүйлийг
тайлбарлах тухай

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2000 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2000 оны дөрөвдүгээр сарын 20 № 14(151)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

165. Засгийн Газрын 2000 оны 24 дүгээр тогтоолын хавсралт “Монгол Улсын Төрийн ёслолын журам” 311

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

166. Хоршооны тухай Монгол Улсын хуулийн зарим зүйлийг тайлбарлах тухай Дугаар 02 319

Монгол улсын Засгийн газрын
2000 оны 24 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ЁСЛОЛЫН ЖУРАМ

Төгсгал. Түрүүч нь
№ 12,13-т гарсан

47. Гадаад улсын Засгийн газрын тэргүүний ажлын айлчлал

47.1. Угтах

Гадаад орны Засгийн газрын тэргүүн Монгол улсад ажлын айлчлалаар ирэхэд нисэх онгоц буюу галт тэрэгний буудалд Монгол улс, тухайн улсын төрийн далбааг мандуулж, нисэх онгоц /галт тэрэг/-ны шатанд гудаслаг улаан хивс дэвссэн байна.

Гадаад улсын Засгийн газрын тэргүүнтэй хийх албан ёсны яриа хэлэлцээнд оролцох Монгол улсын Засгийн газрын нэг гишүүн /хойшид Засгийн газрын гишүүн гэнэ/ нисэх онгоц /галт тэрэг/-ны буудалд гадаад улсын Засгийн газрын тэргүүнийг угтана. Гадаад улсын Засгийн газрын тэргүүн гэргийтэй ирвэл Монгол улсын Засгийн газрын гишүүн гэргийтэй угтана. Ажлын айлчлал хийх Засгийн газрын тэргүүнийг угтах ёслол тусгайлан үйлдэхгүй.

47.2. Бусад зүйл

Монгол улсад анх удаа ирж байгаа гадаад улсын Засгийн газрын тэргүүн /гэргийн хамт/-д монгол үндэсний хувцас /дээл, малгай, бүс, гутал/ бэлэглэнэ. Албан ёсоор дагалдан яваа хумууст дурсгалын зүйл егөх эсэхийг харилцан адил байх зарчмыг харгалзан жич шийдэж байна.

Гадаад улсын Засгийн газрын тэргүүний айлчлалын хетэлберийн хавтас нь монгол болон тухайн улсын төрийн далбааны зурагтай, монгол хэл, тухайн орны буюу харилцан тохиролцсон аль нэгэн хэл дээр хэвлэсэн байна.

48. Гадаад улсын Засгийн газрын тэргүүний хувийн айлчлал

48.1. Угтах

Гадаад улсын Засгийн газрын тэргүүн Монгол улсад хувийн айлчлалаар ирэхэд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга. Ёслолын хэлтсийн дарга нисэх онгоц /галт тэрэг/-ны буудалд угтана. Засгийн газрын тэргүүн гэргийтэй ирвэл Хэрэг эрхлэх газрын дарга гэргийтэй угтана.



48.2. Есполын уулзалт, зоог

Монгол Улсын Ерөнхий сайд Монгол улсад хувийн айлчалаар ирэх гадаад улсын Засгийн газрын тэргүүний хулзэн авч ёсполын уулзалт хийж, зоог барьж болно.

48.3. Бусад зүйл

а/гадаад улсын Засгийн газрын тэргүүний хувийн айлчлалын хугацаанд тусгай зориулалтын машин, бие хамгаалагч гаргаж үйлчлүүлнэ. Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын болон Есполын хэлтсийн ажилтан дагаж үйлчилнэ;

б/ Монгол улсын Ерөнхий сайд хувийн айлчалаараар ирсэн гадаад улсын Засгийн газрын тэргүүнд хувийн бэлзгэвч болно;

в/нисэх онгоц /галт тэрэг/-ны буудал, өргөв, машинд төрийн далбаа мандуулахгүй.

48.4. Үдэх

Монгол улсад хувийн айлчлал хийсэн гадаад улсын Засгийн газрын тэргүүний Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нисэх онгоц / галт тэрэг/-ны буудалд хүргэж ирнэ. Хэрэг эрхлэх газрын даргын гэргий Засгийн газрын тэргүүний гэргийд амьд цэцгийн баглаа барина. Засгийн газрын тэргүүнийг Хэрэг эрхлэх газрын дарга / гэргийн хамт/, Есполын хэлтсийн дарга үдэх мордуулна.

49. Гадаад орны Дэд ерөнхийлөгчийн айлчлал

49.1. Угтах

Монгол Улсад албан ёсны болон ажлын айлчлал хийх гадаад улсын Дэд ерөнхийлөгч / хойшид Дэд ерөнхийлөгч гэнэ/-ийт Дэд ерөнхийлөгчтэй хийх албан ёсны яриа хэлэлцээнд оролцох Монгол Улсын Засгийн газрын гишүүн / хойшид Засгийн газрын гишүүн гэнэ/ нисэх онгоц / галт тэрэг/-ны буудалд утгана.

Нисэх онгоц /галт тэрэг/-ны буудалд Монгол улс, тухайн улсын төрийн далбааг мандуулж, онгоц /галт тэрэг/-ны шатанд гудаслаг улаан хивс дэвсж угтана.

Дэд Ерөнхийлөгчийг Засгийн газрын гишүүн буудалд хүргэж ирнэ. Буудлын дарга Дэд Ерөнхийлөгчийг угтаж авна.

49.2. Дэд ерөнхийлөгчид үйлчлэх автомашин

Монгол улсад албан ёсны болон ажлын айлчлал хийх Дэд ерөнхийлөгчид тусгай зориулалтын машинаар үйлчилнэ. Тусгай зориулалтын автомашины бэлэн байдал, найдвартай ажиллагааг Төр, засгийн Үйлчилгээ,

аж ахуйг эрхлэх газар, Төрийн тусгай хамгаалалтын газар шалгаж урьдчилан бэлтгэсэн байна. Магнай машин гаргаж үйлчилнэ. Тусгай зориулалтын машин, ёслол, хамгаалалтын машинд холбооны аппарат хэрэгсэл сууринуулсан байна.

49.3. Дэд ерөнхийлөгчийн хувийн хамгаалалт

Монгол улсад албан ёсны болон ажлын айлчлал хийх Дэд ерөнхийлөгчид бие хамгаалагч үйлчилнэ. Бие хамгаалагчдыг Төрийн тусгай хамгаалалтын газартай урьдчилан зөвшүүлж зохицуулна.

49.4. Уулзалт, хэлэлцээ

а/Монгол Улсын Ерөнхийлөгч Дэд ерөнхийлөгчийг төрийн хундэтгэлийн өргөвнд хүлээн авч, ёсполын уулзалт хийнэ;

б/Монгол Улсын Засгийн газрын гишүүн албан ёсны болон ажлын айлчлал хийх Дэд ерөнхийлөгчид буудалд нь очиж бараалхаж болно;

в/Монгол улсад албан ёсны болон ажлын айлчлал хийх Дэд ерөнхийлөгчтэй Монгол улсын Их Хурлын дарга буюу Ерөнхий сайд хэлэлцээ хийнэ. Хэлэлцээний ширээнд Монгол улс, тухайн улсын төрийн далбаа, хэлэлцээнд албан ёсоор оролцогсдын нэрс, бичгийн хэрэгсэл тавина. Албан ёсны орчуулагч, тэмдэглэл хөтөлж хүн байна.

49.5. Баримт бичигт гарын үсэг зурах

Дэд ерөнхийлөгчийн албан ёсны болон ажлын айлчлалын үеэр баримт бичигт гарын үсэг зурах ёслол Төрийн ордын "Соёмбо" танхимд болно. Баримт бичигт гарын үсэг зурах ширээнээс баруун гар талд тухайн улсын, зүүн гар талд Монгол улсын төрийн далбаа, гарын үсэг зурах үзэг, бах дарагч, баримт бичиг зэргийг тавина. Гарын үсэг зурахын өмнө баримт бичгийн болон үсэг зурах хүмүүсийн нэрийг хэлж зарлана. Баримт бичигт гарын үсэг зурсан хүмүүс сүүдлаасаас босч баримт бичгээс солилцож гар барина. Баримт бичигт гарын үсэг зурж дуусмагч шамлан дарс барина.

49.6. Хүндэтгэлийн зоог

Дэд ерөнхийлөгчтэй хэлэлцээ хийсэн албан тушаалтанд Дэд ерөнхийлөгчийг хүндэтгэж зоог барина. Зоогийн танхимд Монгол улс, тухайн улсын төрийн далбаа байрлуулна. Зоогийн ширээнд уүч тавьж болно. Зоогийн цэс, уригдагсдын нэрс, хэлэх уг, түүний орчуулга, урлагийн тогтолцын хөтөлбөр зэргийг тавина. Зоогийн өмнө тусгай өргөнд архи, улаан цагаан дарс, пиво, терөл бүрийн ундаагаар апперитив баарина. Зоогийн өмнө тухайн улс, Монгол улсын



терийн дууллыг эгшиглүүлнэ. Төрийн дуулалт эгшиглэхэд бүх хүн босож хүндэтгэнэ.

49.7. Бусад зүйл

а/Монгол улсад албан ёсны болон ажлын айлчлал хийх Дэд ерөнхийлөгчийг тухайн улсад суугаа Монгол улсын Элчин сайд, Есполын хэлтсийн дарга дагаж үйлчилнэ;

Дэд ерөнхийлөгчийн гэргийд тусгай хөтөлбөр бэлтгэж үйлчилнэ.

б/Монгол улсад албан ёсны айлчлал хийх Дэд ерөнхийлөгч, түүний гэргийг оролцуулан 5 хуртэл хүний зардлыг монголын тал хариуцаж болно. Харилцан адил байх зарчмын, тухайн үеийн байдлаас хамаарч зардал даах хүний тоо үүнээс цөөн байж болно;

в/Манай улсад албан ёсны болон ажлын айлчлал хийх Дэд ерөнхийлөгчид /гэргий буюу нэхрийн хамт ирсэн тохиолдолд хоёуланд/ дурсгалын зүйл өгнө;

г/Дэд ерөнхийлөгчийн айлчлалын хөтөлбөрийн хавтас нь Монгол улс, тухайн улсын төрийн далбааны зурагтай, монгол хэл, тухайн орны буюу харилцан тохиролцсон аль нэгэн хэлээр хэвлэсэн байна.

49.8. Үдэх

Монгол улсад албан ёсны болон ажлын айлчлал хийсэн Дэд ерөнхийлөгчийг нисэх онгоц /гэлтэй/ ны буудалд руу хөдлөхөөс эмне Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга /гэргий буюу нэхрийн хамт ирсэн нехцэлд ЕТГ-ын дарга хоёул/ түүний өргөвенд ирж үдэх уулзана. Уулзалтад Есполын хэлтсийн дарга байлцана. Тамгын газрын дарга Дэд ерөнхийлөгчийг нисэх онгоц /гэлтэй/ ны буудалд хүргэж ирнэ. Тамгын газрын дарын гэргий Дэд ерөнхийлөгчийн гэргийд амьд цэцгийн баглаа барина. Дэд ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Есполын хэлтсийн дарга үдэх мордуулна.

Дэд ерөнхийлөгчийг анх утсан Монгол улсын Засгийн газрын гишүүн онгоц /гэлтэй/ ны буудалд хүргэж ирнэ.

Нисэх онгоц /гэлтэй/ ны буудалд Монгол улс, тухайн улсын төрийн далбааг мандуулж, онгоц /гэлтэй/ ны шатанд гудаслаг улаан хивс дэвссэн байна. Дэд ерөнхийлөгчийг нисэх онгоц /гэлтэй/ ны буудлаас Засгийн газрын гишүүн, тухайн улсад суугаа Элчин сайд, Есполын хэлтсийн дарга үдэх мордуулна.

50. Дэд ерөнхийлөгчийн хувийн айлчлал

Дэд ерөнхийлөгч хувийн айлчлал хийхээр ирэхэд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга /зочин гэргий буюу нэхрийн хамт ирсэн тохиолдолд ЕТГ-ын дарга хоёул/, Есполын хэлтсийн дарга

нисэх онгоц /гэлтэй/ ны буудалд утгана.

50.1. Есполын уулзалт

УИХ-ын дарга буюу Ерөнхий сайд Монгол улсад хувийн айлчлалаар ирсэн Дэд ерөнхийлөгчийг хүлээн авч есполын уулзалт хийж, зоог барьж болно.

50.2. Бусад зүйл

Дэд ерөнхийлөгч хувийн айлчлалаар ирэхэд онгоц /гэлтэй/ ны буудал, өргөв, машинд далбаа мандуулахгүй. Айлчлалын хугацаанд тусгай зориулалтын машинаар үйлчилж, Ерөнхийлөгчийн Тамгын газрын болон Есполын хэлтсийн ажилтан дагаж үйлчилнэ.

50.3. Үдэх

Дэд ерөнхийлөгчийг онгоц /гэлтэй/ ны буудал руу хөдлөхөөс эмне Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга /гэргий буюу нэхрийн хамт ирсэн нехцэлд ЕТГ-ын дарга хоёул/ түүний өргөвенд ирж үдэх уулзана. Уулзалтад Есполын хэлтсийн дарга байлцана. Тамгын газрын дарга Дэд ерөнхийлөгчийг нисэх онгоц /гэлтэй/ ны буудалд хүргэж ирнэ. Тамгын газрын дарын гэргий Дэд ерөнхийлөгчийн гэргийд амьд цэцгийн баглаа барина. Дэд ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Есполын хэлтсийн дарга үдэх мордуулна.

51. Гадаад улсын Гадаад хэргийн сайдын айлчлал

51.1. Гадаад хэргийн сайдын Монгол улсад хийх айлчлалыг тэр, засгийн индер албан тушаалтын айлчлалд хамруулна.

51.2. Гадаад улсын Гадаад хэргийн сайдын Монгол улсад хийх айлчлалыг албан ёсны, ажлын, хувийн гэж ангилна.

51.3. Монгол улсын Засгийн газрын урилгаар хоёр талын харилцааны асуудлаар яриа хэлэлцээ хийх буюу томоохон баримт бичигт гарын үсэг зурах зорилгоор гадавд улсын Гадаад хэргийн сайдын тус улсад хийх айлчлалыг албан ёсны айлчлал гэж үзнэ.

51.4. Гадаад улсын Гадаад хэргийн сайд хоёр орны харилцаа, бус нутгийн хийгээд олон улсын харилцааны харилцан сонирхсон асуудлаар зөвлөлдөх, санал солилцож баримт бичигт гарын үсэг зурах, хурал, зөвлөлгөөн, урлаг, соёл, спортын арга хэмжээ, түүхт ой, тэмдэглэлт үйл явдалд оролцох, эмгэнэл илэрхийлэх буюу дамжин өнгөрөх зорилгоор тус улсад хийх айлчлалыг ажлын айлчлал гэж үзнэ.

51.5. Гадаад улсын Гадаад хэргийн сайд



эмчлүүлэх, рашаан сувилалд орох, ан хийх, аялан жуулчлах зорилгоор тус улсад хийх айлчлалыг хувийн айлчлал гэж үзнэ.

51.6. Гадаад улсын Гадаад хэргийн сайд Монгол улсад хийх айлчлалын нэрийг негеэв талтай урьдчилан хэлэлцэж айлчлалын хетөлбөрийг тохиорлоно.

51.7. Монгол улсад албан ёсны болон ажлын айлчлалаар хүрэлцэн ирэх гадаад улсын Гадаад хэргийн сайдыг манай талаас Монгол улсын Гадаад харилааны сайд хүлээж авна.

52. Гадаад хэргийн сайдын албан ёсны болон ажлын айлчлал

52.1. Угтак

Монгол улсад албан ёсны болон ажлын айлчлалаар ирэх гадаад улсын Гадаад хэргийн сайдыг нисэх онгоц /гэлт тэрэг/-ны буудалд угтах ёслолын ажиллагаа адил байна. Нисэх онгоц /гэлт тэрэг/-ны буудалд Монгол улс, тухайн териин далбааг мандуулж онгоц /гэлт тэрэг/-ны шатанд гудаслаг улаан хивс дэвсээн байна.

Гадаад хэргийн сайдыг ГХЯ-ны Териин нарийн бичгийн дарга /зочин гэргий буюу нехрний хамт ирэх тохиолдолт ТНБД хоёул байна/, тухайн улсад суугаа Монгол улсын элчин сайд, ГХЯ-ны Еслолын хэлтсийн дарга угтана. Териин нарийн бичгийн дарга Гадаад хэргийн сайдыг байрлах буудалд нь хүргэж ирнэ. Буудлын дарга зочны угтаж авна. Буудлын ёмне талд тухайн улсын териин далбааг мандуулна.

52.2. Хэлэлцээ, ёслолын болон ганцаарчилсан уулзалт, зоог

Албан ёсны болон ажлын айлчлал хийх Гадаад хэргийн сайдтай Монгол улсын Гадаад харилааны сайд хэлэлцээ хийнэ. Хэлэлцээний ширээнд Монгол улс, тухайн улсын териин далбаа, хэлэлцээнд оролцогсдын нэрс, бичгийн хэрэгсэл тавьсан байна.

Гадаад хэргийн сайд ГХЯ-нд анх ирэхэд гол хаалганы зүүн, баруун талд Монгол улс, тухайн улсын териин далбааг мандуулсан байна.

52.3. Еслолын уулзалт

Монгол улсад албан ёсны болон ажлын айлчлал хийх Гадаад хэргийн сайдыг Монгол улсын тэр, засгийн удирдлагад бараалхуулна. Албан ёсны оруулагч, тэмдэглэл хотлөх хүн байна.

52.4 Ганцаарчилсан уулзалт

Монгол улсын Гадаад харилааны сайд гадаад улсын Гадаад хэргийн сайдтай ганцаарчилсан уулзалт хийж болно.

52.5. Хүндэтгэлийн зоог

Гадаад харилааны сайд албан ёсны болон ажлын айлчлал хийх гадаад улсын Гадаад хэргийн сайдыг хүндэтгэн зоог барина. Зоогийн ёмне тухайн улсын болон Монгол улсын териин дуулалт эгшиглүүлнэ. Зоогийн гол ширээг амьд цэцэр чимж, зоогийн цэс, оролцогсдын нэрийг тавьсан байна. Харилаан уг хэлж хундагаа ергене. Зоогийн үеэр улаан, цагаан дарс, төрөл бүрийн ундаагаар үйлчилнэ.

52.6 Баримт бичигт гарын үсэг зурах

Баримт бичигт гарын үсэг зурах эслол ГХЯ-ны бага танхимд буюу хэлэлцээний өрөөнд болно. Үсэг зурах ширээн дээр зүүн гар талд монгол улсын, баруун гар талд тухайн улсын териин далбааг эзрэгцүүлэн тавина. Үзэг, бэх дарагч, үсэг зурах баримт бичигт зэргийг тавина. Үсэг зурахын ёмне баримт бичгийн болон үсэг зурах хумуусийн албан тушаал, овог, нэрийг хэлж зарлана. Баримт бичигт гарын үсэг зурсан хумуус суудлаасаа босч баримт бичгээ харилаан солилцно. Ёслолд оролцогсод шампан дарс барина.

52.7. Бусад зүйл

а/Гадаад хэргийн сайд албан ёсны болон ажлын айлчлал хийх хугацаанд тухайн улсад суугаа Элчин сайд, Еслолын хэлтсийн ажилтан дагаж үйлчилнэ. Гадаад хэргийн сайдын гэргийд тусгай хетөлбөр бэлтгэж үйлчилнэ;

б/албан ёсны айлчлал хийх Гадаад хэргийн сайд, түүний гэргийг оролцуулан 5 хүртэл хүний зардлыг монголын тал хариуцаж болно. Харилаан адил байх зарчим, тухайн үеийн байдлаас хамаарч зардал даах хүний тоо үүнээс цөөн байж болно;

в/албан ёсны болон ажлын айлчлал хийх Гадаад хэргийн сайдын айлчлалын хетөлбөрийн хавтас нь Монгол улс, тухайн улсын териин далбааны зурагтай, монгол хэл, тухайн орны буюу харилаан тохиолцсон аль нэгэн хэл дээр хэвлэсэн байна;

г/Монгол улсын Гадаад харилааны сайд гадаад улсын Гадаад хэргийн сайдад (гэргий/нэхэр) монгол үндэсний дурсгалын зүйл өгнө;

д/албан ёсны болон ажлын айлчлал хийх Гадаад хэргийн сайдад тусгай зориулалтын машин, магнай машин, бие хамгаалагч гаргаж үйлчилнэ.

52.8. Үдэх

Албан ёсны болон ажлын айлчлал хийж



байгаа Гадаад хэргийн сайд нисэх онгоц /гант тэрэг/-ны буудал руу хедлехөөс өмнө Гадаад харилцааны сайд /Эрэгий/ түүний бусан өргөвнд очиж үзэлтийн уулзант хийнэ. Уулзантад Монголын элчин сайд, ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Еслолын хэлтсийн дарга байлцана. Уулзантын төгсгөлд Гадаад харилцааны сайд айлчлалын үеийн гэрэл зургийн цомгийг Гадаад хэргийн сайдад дурсгана. Гадаад хэргийн сайдын гэргийд амьд цэцгийн баглаа барина.

Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Гадаад хэргийн сайдтад хамт нисэх онгоц /гант тэрэг/-ны буудалд ирнэ.

Нисэх онгоц /гант тэрэг/-ны буудал Монгол улс, тухайн улсын төрийн далбааг мандуулж, онгоц /гант тэрэг/-ны шатанд гудаслаг улаан хивс давссан байна. Гадаад хэргийн сайдыг Төрийн нарийн бичгийн дарга/Эрэгий буюу нехрүн хамт ирсэн тохиолдолд Төрийн нарийн бичгийн дарга хоёул байна/, Элчин сайд, Еслолын хэлтсийн дарга үдэж мордуулна.

53. Гадаад хэргийн сайдын хувийн айлчлал

53.1. Угтах

Гадаад улсын Гадаад хэргийн сайд монгол улсад хувийн айлчлалаар хүрэцэн ирэхэд Гадаад харилцааны яамны чиглэлийн газрын ахлах мэргжилтэн, Еслолын хэлтсийн ажилтны хамт угтана.

53.2 Еслолын уулзалт, зоог

Монгол улсын Гадаад харилцааны сайд хувийн айлчлалаар ирэх гадаад улсын Гадаад хэргийн сайдыг хулзэн авч уулзаж зоог барина. Гадаад харилцааны сайд хувийн бэлзэг, дурсгалын зүйл егч болно.

53.3. Бусад зүйл

Гадаад хэргийн сайдын хувийн айлчлалын хугацаанд түүнд тусгай зориулалтын машинаар үйлчилнэ. Нисэх онгоц /гант тэрэг/-ны буудал, байрлах өргөв, машинд далбаа мандуулхагүй. Хувийн айлчлалаар ирсэн Гадаад хэргийн сайдыг утгсан хүмүүс үдэж мордуулна.

54. НҮБ-ЫН ЕРЕНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЙЛЧЛАЛ

54.1. Угтах

НҮБ-ЫН Ерөнхий нарийн бичгийн дарга / Ерөнхий нарийн бичгийн дарга гэнэ/ айлчилж ирэхд нисэх онгоц /гант тэрэг/-ны буудал Монгол улс, НҮБ-ын далбааг мандуулж ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга угтана. Ерөнхий нарийн бичгийн дарга гэргийтэй ирэх тохиолдолд Төрийн нарийн бичгийн дарга гэргийтэй угтана. Төрийн нарийн бичгийн дарга Ерөнхий нарийн

бичгийн даргыг буух буудалд нь хүргэж ирнэ.

Ерөнхий нарийн бичгийн даргын байрлах байрны гадаа НҮБ-ын далбааг мандуулна.

54.2. Ерөнхий нарийн бичгийн даргад үйлчлэх машин, хамгаалалт

Монгол улсад айлчлал Ерөнхий нарийн бичгийн даргад тусгай зориулалтын машин, магнай машин, бие хамгаалагч гаргаж үйлчилнэ. Гол машин, ёслол, хамгаалалтын машинд холбоо барих аппарат хэрэгсэл сууринуулсан байна.

54.3. Хэлэлцээ, ёслолын уулзалт, зоог

54.3.1. Хэлэлцээ

Монгол улсын Гадаад харилцааны сайд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргатай ГХЯ-нд хэлэлцээ хийнэ. Хэлэлцээ хийх үеэр ГХЯ-ны гол хаялганы баруун талд НҮБ-ын далбаа, зүүн талд Монгол улсын төрийн далбааг мандуулна. Хэлэлцээний ширээн дээр амьд цэцэг, Монгол улс, НҮБ-ын далбаа, хэлэлцээнд албан ёсоор оролцогсдын нэрс, бичгийн хэрэгсэл тавина.

54.3.2. Уулзалт

Монгол улсад айлчилж буй НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдад бараалхуулна. Албан ёсны орчуулагч, тэмдэглэл хөтөлбөх хүн байна.

54.3.3. Хүндэтгэлийн зоог

Монгол улсын Гадаад харилцааны сайд Ерөнхий нарийн бичгийн даргад хүндэтгэлийн зоог барина. Зоогийн ширээн дээр амьд цэцэг, ургидсан хүмүүсийн нэрс, зоогийн цэс тавина. Аллеритив барыш болно.

Хүндэтгэлийн зоогийн үеэр Гадаад харилцааны сайд, Ерөнхий нарийн бичгийн дарга харилцан уг хэлж, хундага өргөж болно. Зоогийн үеэр улаан, цагаан дарс, төрөл бүрийн ундаагаар үйлчилнэ.

54.4. Бусад зүйл

Ерөнхий нарийн бичгийн даргыг айлчлах хугацаанд НҮБ-ын дэргэд суугаа Монгол улсын Байнгын төлөвлөгөөч-Элчин сайд, Еслолын хэлтсийн дарга дагах үйлчилнэ. Ерөнхий нарийн бичгийн даргын гэргийд тусгай хөтөлбөр бэлтгэж үйлчилнэ.

Ерөнхий нарийн бичгийн даргын айлчлалын хөтөлбөрийн хавтас нь Монгол улсын болон НҮБ-ын далбааны зурагтай, монгол, англи хэл дээр хэвлэсэн байна.

Гадаад харилцааны сайд Ерөнхий нарийн



бичгийн даргад дурсгалын зүйл ёгне.

54.5. Үдэх

Ерөнхий нарийн бичгийн дарга нисэх онгоц /галт тэрэг/-ны буудал руу хөдлөхөөс эмнэ Гадаад харилцааны сайд Ерөнхий нарийн бичгийн даргын буусан байранд очиж үдэлтийн уулзалт хийнэ. Уулзалтад ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Монгол улсын Байнгын төлөөлөгч-Элчин сайд, Еслолын хэлтсийн дарга байлцана.

Гадаад харилцааны сайд Ерөнхий нарийн бичгийн даргад айлчлалын холбогдолтой гэрэл зургийн цомгийг дурсгана.

ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Ерөнхий нарийн бичгийн даргыг нисэх онгоц /галт тэрэг/-ны буудалд хүргэж ирнэ. Онгоц /галт тэрэг/-ны буудалд монгол улсын болон НҮБ-ын далбааг мандуулна. Ерөнхий нарийн бичгийн даргыг ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Байнгын төлөөлөгч-Элчин сайд, Еслолын хэлтсийн дарга үдэж мордуулна.

55. НҮБ-ын системийн болон Засгийн газар хоорондын олон улсын бусад байгууллагын тэргүүний айлчлал

55.1. Угтах

НҮБ-ын системийн болон Засгийн газар хоорондын олон улсын бусад байгууллагын тэргүүн /ОУБ-ын тэргүүн гэнэ/ Монгол улсад айлчлахад нисэх онгоц /галт тэрэг/-ны буудалд Монгол улс, тухайн ОУБ-ын далбааг мандуулна.

Тухайн ОУБ-тай хамгийн өргөн харилцаатай яамны Төрийн нарийн бичгийн дарга нисэх онгоц /галт тэрэг/-ны буудалд ОУБ-ын тэргүүний утгана.

Төрийн нарийн бичгийн дарга ОУБ-ын тэргүүний буух буудалд нь хүргэж ирнэ. ОУБ-ын тэргүүний буудлын дарга угтаж авна. Буудлын гадаа тухайн ОУБ-ын далбааг мандуулна.

55.2. ОУБ-ын тэргүүнд үйлчлэх машин, хамгаалалт

Монгол улсад айлчлах ОУБ-ын тэргүүнд тусгай зориулалтын машин, бие хамгаалагч гаргаж үйлчилнэ.

55.3. Хэлэлцээ, уулзалт, зоог

55.3.1. Хэлэлцээ

Тухайн ОУБ-тай хамгийн өргөн харилцаатай салбарыг хариуцсан Засгийн газрын гишүүн ОУБ-ын тэргүүнтэй хэлэлцээ хийнэ.

Хэлэлцээний ширээнд Монгол улсын болон тухайн ОУБ-ын далбаа, хэлэлцээнд албан ёсоор оролцогсдын нэрс, бичгийн хэрэгслэв тавина. Албан ёсны орчуулагч, тэмдэглэл хетхэл хүн байна.

55.3.2. Еслолын уулзалт

Монгол улсын Ерөнхий сайд ОУБ-ын тэргүүний хүлээн авч уулзана. Шаардлагатай гэж узвэл Монгол Улсын Ерөнхийлөгчид бараалхуулж болно.

55.3.3. Хүндэтгэлийн зоог

Хэлэлцээ хийсэн Засгийн газрын гишүүн ОУБ-ын тэргүүний хүндэтгэн зоог барина. Апперитив барина. Засгийн газрын гишүүн, ОУБ-ын тэргүүн нар харилцан уг хэлж, хундага өргөнэ. Зоогийн үеэр улаан, цагаан дарс, төрөл бүрийн ундаагаар үйлчилнэ.

55.4. Бусад зүйл

55.4.1. ОУБ-ын тэргүүний айлчлах хугацаанд тухайн ОУБ-тай өргөн харилцаатай холбогдох яамны газрын дарга, мөн яамны гадаад харилцаа хариуцсан ажилтан дагаж үйлчилнэ.

55.4.2. ОУБ-ын тэргүүний айлчлалын хетелберийн хавтас Монгол улсын болон тухайн ОУБ-ын далбааны зурагтай, монгол, англи хэл дээр хэвлэгдсэн байна. ОУБ-ын тэргүүнд түүнтэй хэлэлцээ хийсэн Засгийн газрын гишүүн дурсгалын зүйл ёгне.

55.5. Үдэх

ОУБ-ын тэргүүн нисэх онгоц /галт тэрэг/-ны буудал руу хөдлөхөөс эмнэ түүнтэй хэлэлцээ хийсэн Засгийн газрын гишүүн түүний буусан буудалд очиж үдэлтийн уулзалт хийнэ. Уулзалтад ОУБ-ын тэргүүний утгсан хүмүүс байлцана. Уулзалтын төгрөглөд ОУБ-ын тэргүүнд айлчлалын холбогдолтой гэрэл зургийн цомог дурсгана.

ОУБ-ын тэргүүний анх утгсан холбогдох яамны Төрийн нарийн бичгийн дарга ОУБ-ын тэргүүний онгоц /галт тэрэг/-ны буудалд хүргж ирнэ.

Нисэх онгоц /галт тэрэг/-ны буудалд Монгол улс, тухайн ОУБ-ын далбааг мандуулна. ОУБ-ын тэргүүний Төрийн нарийн бичгийн дарга, Еслолын хэлтсийн дарга үдэж мордуулна.

56. Гадаадын төр, засгийн газар, парламентын тэргүүн асан хүний айлчлал

56.1. Гадаад орны төр, засгийн газар, парламентын тэргүүн асан хүн /хойшид тэргүүн асан гэнэ/ манай урилгаар айлчлахад Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхэлэх газар, УИХ-ын Тамгын



газрын болон Есполын хэлтсийн ажилтан утгаж, үднэ. Тэргүүн асны Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга хүлээн авч уулзаж, зоог барина. Түүнийг тэр, засгийн газар, парламентын тэргүүн нарын аль нэгэнд бараалхуулж болох бөгөөд хэнд бараалхуулахыг жич зохицуулна.

Тэргүүн асанд тусгай зориулалтын машинаар үйлчилнэ. Харин бие хамгаалагч ажиллуулах, магнайн машин гаргах эсэхийг жич шийдвэрлэнэ. Онгоц /гант тэрэг/-ны буудал, өргөв, машинд төрийн далбаа мандуулахгүй.

57. Гадаадын төрийн тэргүүний угсаа залгамжлах хунтайж, гүнжийн айлчлал

57.1. Гадаад орны төрийн тэргүүний угсаа залгамжлах хунтайж, гүнжийн Монгол улсад хийх айлчлалын нэр, хөтөлбөрийг хоёр тал урьдчилан тохиролцно.

57.1.1. Гадаад орны төрийн тэргүүний угсаа залгамжлах хунтайж, гүнжийг утгах, үдэх газар, буудаллах харш, унаанд нь тухайн хүнд хамаарах далбааг мандуулж болно.

57.1.2. Монгол улсад гадаад орны төрийн тэргүүний угсаа залгамжлах хунтайж, гүнжийг айлчлахад нисэх онгоц /гант тэрэг/-ны буудалд Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Есполын хэлтсийн дарга утгаж, үдэх бөгөөд Гадаад харилцааны сайд зоог барина. Харин шаардлагатай гэж узвэл Еренхийлэгчид бараалхуулж болно.

57.1.3. Гадаад орны төрийн тэргүүний угсаа залгамжлах хунтайж, гүнжийн Монгол улсад айлчлахад Еренхийлэгчийн Тамгын газар, ГХЯ-ны Есполын хэлтсийн ажилтан дагах үйлчилнэ.

57.1.4. Гадаад орны төрийн тэргүүний угсаа залгамжлах хунтайж, гүнжийн Монгол улсад хийх айлчлалын хөтөлбөрийн хавтсиг төрийн далбаны зурагтгуй, монгол хэл, тухайн улсын буюу харилцан тохиролцсон аль нэг гадаад хэл дээр хэвлүүлнэ.

58. Холбооны улсын бүрэлдэхүүнд багтдаг Бугд найрамдах улсын тэр, засгийн газрын тэргүүн, парламентын даргын айлчлал

58.1. Холбооны улсын бүрэлдэхүүнд багтдаг Бугд Найрамдах улсын тэр, засгийн тэргүүн/БНУ-ын тэр, засгийн газрын тэргүүн гэнэ/, парламентын даргын Монгол улсад хийх албан ёсны болон ажлын айлчлалыг гадаад улсын тэр, засгийн газрын ондөр албан тушаалтын айлчлалд хамруулна.

58.1.1. Утгах

БНУ-ын тэр, засгийн газрын тэргүүн, парламентын даргыг нисэх онгоц /гант тэрэг/-ны

буудалд Монгол Улсын Еренхийлэгчийн Тамгын газрын дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, УИХ-ын Тамгын газрын Еренхий нарийн бичгийн дарга буюу тэдэнтэй адилтгах зиндааны албан тушаалтад Есполын хэлтсийн даргын хамт утгаж үднэ. Нисэх онгоц /гант тэрэг/-ны буудалд Монгол улс, Холбооны улсын төрийн далбааг мандуулж болно. Нисэх онгоц /гант тэрэг/-ны шатанд гудаслаг улаан хивс дэвссэн байна. БНУ-ын тэр, засгийн тэргүүн, парламентын дарга автомашинаар ирэх тохиолдолд утгах ёсполыг Улаанбаатар хотын гадна товлосон газарт зохион байгуулж болно.

58.1.2 Төрийн далбаа хэрэглэх

БНУ-ын тэр, засгийн газрын тэргүүн, парламентын даргын хөлөглөх машин, байрлах өргөөнд тухайн БНУ-ын төрийн далбаа мандуулж болно. БНУ-ын тэр, засгийн тэргүүн, парламентын даргын хэлэлцээс хийх, баримт бичигт гарын үсэг зурах ширээнд Монгол улс, тухайн БНУ, Холбооны улсын төрийн далбааг байрлуулна. Харин Монгол улсын төрийн далбаа, тухайн БНУ-ын далбааг зэрэгцүүлэн хэрэглэж үл болно.

58.1.3. Хэлэлцээ, зоог

Монгол улсын Засгийн газрын аль нэг гишүүн БНУ-ын тэр, засгийн газрын тэргүүнтэй, УИХ-ын дэд дарга парламентын даргатай Төрийн ордонд албан ёсны хэлэлцээ хийж, зоог барина. Хэлэлцээ, зоогт тухайн Холбооны улсын Элчин сайд /сайд эзгүй үед хэргийг түр хамарагч-/ыг урьж урина.

58.1.4. Уулзалт

Монгол улсын тэр, засгийн газрын тэргүүн, УИХ-ын даргад БНУ-ын тэр, засгийн газрын тэргүүн, парламентын даргыг тус туслын шугамаар бараалхуулж болно. Бараалхах уулзалтыг Төрийн ордны уулзалтын танхимд зохион байгуулна. Уулзалтад тухайн Холбооны улсын Элчин сайд /сайд эзгүй үед хэргийг түр хамарагч-/ыг урьж оролцуулна.

58.1.5. Бусад зүйл

а/ БНУ-ын тэр, засгийн газрын тэргүүн, парламентын даргыг айлчлалын үеэр Еренхийлэгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, УИХ-ын Тамгын газар, Есполын хэлтсийн ажилтан дагаж үйлчилнэ;

б/ БНУ-ын тэр, засгийн газрын тэргүүн, парламентын даргад тусгай зориулалтын машин, бие хамгаалагч, магнайн машин гаргаж үйлчилнэ;



в/ Монгол улсын Засгийн газрын аль нэг гишүүн, УИХ-ын дад даргын нэрээр БНУ-ын тэр, засгийн газрын тэргүүн, парламентын даргад монгол үндэсний бэлзг дурсгалын зүйл егч болно;

г/ БНУ-ын тэр, засгийн газрын тэргүүн, парламентын дарга албан ёсоор айлчлахад тэргүүнийг оролцуулан 5 хуртэл хүний зардлыг монголын тал дааж болно. Харилцаан адил байх зарчим, тухайн үеийн байдлаас хамаарч зардал даах хүний тоо үүнээс цөөн байж болно.

59. Хэвлэл мэдээлэл

59.1. Энэ журамд заасан дипломат ёсполын аливаа арга хэмжээг нийтэд мэдээлэх, түүнд гадаад, дотоодын хэвлэл мэдээллийн ажилтнуудыг хэрхэн хамруулахыг Гадаад харилцааны яам, Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын Тамын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай зөвшиндэн зохион байгуулна.

59.1.1. Дипломат ёсполын арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх ажлыг Гадаад харилцааны яам хариуцан зохицуулж байна.

59.1.2. Монгол Улс гадаад улсын тусгаар тогтолыг хүлээн зөвшөөрсөн болон гадаад улстай албан ёсны дипломат харилцааны тогтоосон тухай албан ёсны шийдвэрийг тухайн улстай тохиролцсоны үндсэн дээр харилцаан адил байх зарчмыг баримтлан хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

59.1.3. Монгол улсаас гадаад орон, Засгийн газар хоорондын олон улсын байгууллагад ДТГ нээсэн, ДТГ-ын тэргүүн Итгэмжлэх жуух бичиг болон Итгэмжлэх захидал гардуулсан тухайг хэвлэл, радио, телевизээр мэдээлнэ.

59.1.4. Монгол улсын тэр, засгийн дээд албан тушаалтан болон Гадаад харилцааны сайд гадаад улсын тэр, засгийн тэргүүн, Гадаад хэргийн сайд, ОУБ-ын удирдлагад баяр хүргэсэн, змгнэл илэрхийлсэн хийгээд тухт ой, тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан цахилгаан утас солилцсон, тэдгээрийн хурал чуулган, бусад арга хэмжээнд оролцсон, уг хэлсэн тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

59.1.5. Дипломат харилцаа бүхий гадаад улсын үндэсний баярыг тохиолдуулан хоёр талын харилцааны тувшин, харилцаан адил байх зарчмыг баримтлан хэвлэл мэдээллийн хэрэгслэл тус улсад суугаа ДТГ-ын тэргүүнээс ярилцлага авах, уг хэлүүлэх, дээд болон ёндер хэмжээнд солилцсон баярын цахилгаан утсуудыг нийтлэх, ДТГ-аас оид

зориулан зохиосон арга хэмжээг мэдээлэх зэрэгээр ажиллаж болно.

59.2. Монгол Улсын тэр, Засгийн газрын дээд, ёндер албан тушаалтан, Гадаад харилцааны сайдын айлчлалыг мэдээлэх.

59.2.1. Монгол улсын тэр, Засгийн газрын дээд, ёндер албан тушаалтан, Гадаад харилцааны сайд гадаадад албан, ажлын айлчлал хийх тухай товч мэдээг уг айлчлал эхлэхээс долоогоос доошгүй хоногийн өмнө хэвлэлд нийтэлж, айлчлахаар мордсон, айлчлалын явц, эргэжирсан талаар тухай бүр мэдээлнэ. Монгол улсын тэр, Засгийн дээд, ёндер албан тушаалтан гадаадад албан ёсны болон ажлын айлчлал хийхэд хэвлэл мэдээллийн болон баримтат киноны хэсэг дагалдаж болно.

59.3. Гадаад улсын тэр, засгийн газрын дээд албан тушаалтны айлчлалыг мэдээлэх

59.3.1. Манай улсад гадаад улсын тэр, засгийн газрын дээд албан тушаалтан албан ёсны болон ажлын айлчлал /хойшид айлчлал гэнэ/ хийх тухай мэдээг айлчлал эхлэхээс авраас доошгүй хоногийн өмнө, тухайн хүний гэрэл зураг, намтыг айлчлал эхлэхээс нэг хоногийн өмнө буюу айлчлал эхлэх ёдөр нийтэлнэ. Айлчлалын хөтөлбөрт заасан арга хэмжээний үеэр хэвлэлийн хэсэг дагалдан сурвалжилж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухай бүр мэдээлж байна.

59.3.2. Гадаад, дотоодын хэвлэл мэдээллийн хэсэг, гэрэл зурагчид, киноны болон төлөвийн зураглаачдыг хэлэлцээ, хундэтгэлийн зоог зэрэг зарим арга хэмжээний эхэнд 3 минутас илүүгүй хугацаанд багтаан сурвалжлага хийлгэж болно.

59.3.3. Айлчлалын тухай хэвлэлийн бага хурал, хэвлэлийн уулзалт, ганцаарчилсан болон хэсэгчилсэн ярилцлага зэргийг хоёр орны харилцааны тувшин, харилцаан адил байх зарчмыг баримтлан ГХЯ-наас аль тохиромжтой хэлбэрээр зохион байгуулна.

59.3.4. Монгол улсад албан болон ажлын айлчлалаар хүрэлцэн ирэх Гадаад улсын тэр, засгийн дээд, ёндер албан тушаалтны дагалдан явваа хэвлэлийн хэсгийн үйл ажиллагааг Гадаад харилцааны яам эрхлэн зохион байгуулна.

59.4. Итгэмжлэх жуух бичиг, Итгэмжлэх захидал гардуулсан тухай мэдээлэх

59.4.1. Монгол улсын Ерөнхийлөгч гадаад ороос тус улсад суух Элчин сайдын Итгэмжлэх жуух бичигийг, Гадаад харилцааны сайд ОУБ-ын сурин төлөвлөгөө, гадаад улсын хэргийн хамаарч нарын Итгэмжлэх захидалыг хүлээн авсан тухай хэвлэл мэдээллийн бүх хэрэгслээр мэдээлнэ.



Чингэхдээ Итгэмжлэх жуух бичиг, Итгэмжлэх захидалыг гардуулж буй болон холбогдох хүмүүс харилцан үг хэлж байгааг төлөвзээр дамжуулна.

Гадаад улсаас тус улсад суух анхны элчин сайд томилогдон ирэхд баримттай кино зураг авч архивт хадгална.

59.5. Уулзалтуудыг мэдээлэх

59.5.1. Төр, засгийн дээд болон ёндөн албан тушаалтан ДТГ-ын тэргүүнийг хүлээн авч уулсан, дипломат ёслолын арга хэмжээ зохиосон тухай хэвлэлээр төв мэдээлж болно.

59.5.2. Монгол улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд ДТГ-ын тэргүүнийг өөрсдийн санаачилгаар болон тэдний хүснэгтээр, мөн эх орондоо бүрмөсөн буцахтай нь холбогдуулан хүлээн авч уулсан тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж болно.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2000 оны 1 дүгээр
сарын 19-ний өдөр

Дугаар 02

Улаанбаатар
 хот

ХОРШООНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛИЙГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

"Хоршооны тухай" Монгол Улсын Хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг нэг мөр ойлгох зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдуугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дүгээр заалт, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 6 дугаар заалтыг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Хоршооны тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг дор дурьдсандаа тайлбарласугай.

1. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дахь заалтын "хоршоо нь үйл ажиллагааныхаа улмаас бий болсон үүргийг зөвхөн өөрийн /хоршооны/ эд хөрөнгөөр хариуцна" гэсэн заалтын "хоршооны өөрийн эд хөрөнгө" гэдэгт тухайн хоршооны санхүүгийн данс бүртгэлд байгаа үндсэн болон эргэлтийн эд хөрөнгийн зүйлийг хамааруулан ойлгох бөгөөд түүний хэмжээг тодорхойлоходо татварын байгууллагад хамгийн суулд гаргасан тайлан тэнцэл уг тайлан тэнцлийг баталгаажуулсан шинжилгээ дүгнэлтийг үндэслэн нийт үндсэн ба эргэлтийн хөрөнгөөс

60. Бусад зүйл

60.1. Монгол улсын териин ба териин бус, хоршооллын болон хувийн хэвлэлийн нийт байгууллага, иргэд териин ёслолын журамтай холбогдуулан хүлээсэн үргээ ёслолын биелүүлж, энэ талаар Төрийн ёслолын алба, Гадаад харилцааны яамны Ёслолын хэлтэстэй хамтарч ажиллах үүрэгтэй.

60.2. Гадаад харилцааны яам энэ журамд зассан териин дипломат ёслолын үйл ажиллагааг тухайн цаг үеийн онцлог, гадаад улс, олон улсын байгууллагын ёслолын журам, олон улсын харилцааны тухайн үеийн практикт нийцүүлж зохиж болно.

60.3. Энэ журамд урьдчилан заагдаагүй айлчлал болон бусад арга хэмжээний талаар мэдээлэх, сурталчлах ажлыг уг журмын жишиж болох төрөл зүйлтэй адилтган зохицуулна.

бусдад төлөх төлбөрийн хэмжээг хассан зөрүүгээр хоршооны өөрийн хөрөнгийн хэмжээг тогтооно.

Хоршоо нь үйл ажиллагааныхаа улмаас бий болсон үүргийг өөрийн эд хөрөнгийн хэмжээгээр хариуцна.

2. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтын "хоршооны эд хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд түүний үүргийг гишүүд нь нехеж хариуцна" гэдгийг хоршоо үйл ажиллагааныхаа улмаас бий болсон үүргийг хариуцах явцад түүний өөрийн эд хөрөнгө нь хүрэлцэхгүй болсон тохиолдолд хоршооныхоо үүрэг өр төлбөрийг гишүүд нехеж төлнэ. Ийнхүү гишүүн нехеж хариуцлага хүлээхдээ Иргэний хуулийн 95 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу хоршооны дурмээр тогтоосон хэмжээнд гэр булийн эд хөрөнгөөс өөрт оногдох хэсгээр хариуцна гэж ойлгох хэрэглэнэ.

3. Мөн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтын "гышүүдийн хүлээх нехех хариуцлагын хэмжээг хязаарлах эсэхийг дурмээр зохицуулна" гэдгийг нехех хариуцлагын төлбөрийг хоршооны эд хөрөнгөөс гишүүнд оногдох хэмжээтэй



харьцуулан хязгаарлах эсэх, түүнчлэн хоршоонд хөдөлмөрийн оролцоо, оюуны өмч зэргийг нийлүүлсэн гишүүн нехex харицлагага хулээх эсэх болон гишүүдийн нехex харицлагага хулээх талаарх асуудал хоршооны дүрэмд зааснаар зохицуулагдана гэж ойлгоно.

4.Хуулийн 10.1, 23.8, 23.11 дүгээр заалтын "гишүүдийн дийлэнх олонхиин саналаа" гэдгийг хоршооны хуралд оролцогчдын гуравны хоёр буюу 66.6 хувийн саналаар гэж ойлгох бөгөөд харин хуулийн 23.5 дугаарт заасан "дийлэнх олонхи" гэдгийг хоршооны бүх гишүүдийн гуравны хоёр оролцсоороо бүх гишүүдийн хурал хүчин төгөлдөрт тооцогдоно гэж ойлгож хэрэглэнэ.

5.Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх заалтын "өргөдөл гаргагчид албан ёсоор мэдэгдэж, баримт бичгийг нь буцаана" гэдэг нь хоршоог бүртгүүлэх өргөдөл, түүнд хавсаргасан бичиг баримтыг хүлээн авч бүртгэх ажиллагаа явуулах явцад, ирүүлсэн өргөдөл бичиг баримт хоршооны хуульд заасан шаардлага хангагүй гэж узвэл, бүртгэх байгууллага нь зохих үндэслэлийг тодорхой зааж, бүртгэхээс татгалзсан шийдвэр гаргаж, уг шийдвэрийг өргөдөл гаргагчид баримт бичгийн хамт буцаан хүргүүлэхийг хэлнэ.

6.Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтын "хоршоог улсын бүртгэлд бүртгэсэн тухай бүртгэх байгууллага нийтэд мэдээлнэ" гэдэг нь бүртгэх байгууллагаас хоршоог улсын бүртгэлд бүртгүүлсэн тухай төв, орон нутгийн өдөр дутмын сонин, радио, телевиз болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл буюу нийтэд хүртэлтэй бусад аргаар мэдээлсэн байхыг хэлнэ.

7.Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтын "Түүний үйлчилгээг ашиглаж, холбогдох харицлагы хүлээх чадвартай иргэн" гэдэг нь хоршооноос явуулж байгаа үйл ажиллагааг биечлэн дэмжиж, түүний үйлчилгээг өөрийн ахуй амьдралдаа ашиглах талаар хоршооны дүрмээр тогтоосон эрх үүргийг зөвшөөрч уг хоршооны үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээнээс үүссэн үүргийг хоршоонд нийлүүлсэн эд хөрөнгөөрөө болон гэр бүлийн эд хөрөнгийн өөрт оногдох хэсгээр нехэн төлөх чадвартай, арванзургаан нас хүрсэн хүнийг хамааруулан ойлгоно.

8.Хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтын "хоршооны гишүүн хууль, дүрэмд заасан үүргээ зөрчсөн" гэдэгт хоршооны гишүүн нь хоршооны тухай хууль тогтоомжоо болон өөрийн хоршооны дүрэмд заасан заавал биелүүлбэл зохих үүргээ зөрчсөн явдлыг

хамааруулна.

Хоршооны гишүүн үүргээ зөрчсөнөөс тухайн хоршооны хэвийн үйл ажиллагаа алдагдсан, түүнд бага бус хэмжээний хохирол учирсан, явуулбал зохих үйлдвэрлэл үйлчилгээ тасалдсан, түүнчлэн тухайн гишүүний оролцотойгоор явагддаг үйлдвэрлэл үйлчилгээ зогсоосон буюу өөрчлөхдөх хүрсэн зэрг үр дагавар бий болгосон явдал нь түүнийг хоршооны гишүүнээс хасах үндэслэл болж болно.

Түүнчлэн хоршооны гишүүн хууль дүрэмд заасан үүргээ зөрчсөн үндэслэлээр түүнийг гишүүнээс хасах тухай Тэргүүлэгчдийн сануулга авсны дараа уг зөрчлийг дахин гаргасан явдал нь хоршооны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын дагуу гишүүнийг хоршооны гишүүнээс хасах үндэслэл болно.

9.Хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтын хоршооны гишүүн өөрийн оруулсан хувь хөрөнгийг бичээр хийсэн гэрээний дагуу өөр гишүүнд хэдийд ч шилжүүлж болно" гэдгийг хоршооны гишүүн нь өөрийн оруулсан хувь хөрөнгөө бүрэн буюу зарим хэсгийг тухайн хоршооны бусад гишүүддээз бэлзгэх, худалдах төлбөрт өгөх зэргээр бичгээр гэрээ байгуулах замаар шилжүүлж болно гэж ойлгоно. Харин тус хоршооны гишүүн бус этгээдэд шилжүүлэхгүй. Хоршооны гишүүн өөрийн оруулсан хувь хөрөнгийг гишүүн бус этгээдэд шилжүүлэх зайлшгүй шаардлага бий болсон бол тухайн этгээд нь хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан журмын дагуу уг хоршооны гишүүнээр элсэж, бүртгэх байгууллагад бүртгүүлсэн дараа түүнд өөрийн хувь хөрөнгөө шилжүүлэх эрх нээгдэнэ.

10.Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалтын "өөв залгамжлагч нь хоёр түүнээс дээш байвал гишүүнчлэлийн асуудлыг шийдвэрлэх хүртэл саналын нэг эрхтэй" гэдгийг хоршооны гишүүн нас барсны дараа түүний эд хөрөнгийн эрхийг өөв залгамжлагч нь хоёроос дээш этгээд байвал тэдгээрийн гишүүнчлэлийн асуудлыг хоршооны бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэж, түүнийг бүртгэх байгууллагад бүртгүүлэх хүртэл хугацаанд саналын нэг эрхтэй байна гэж ойлгож хэрэглэнэ.

11.Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь заалтын "гишүүдийн гуравны нэгзээс доогүй хувийн саналаар бүх гишүүдийн эзлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно" гэдэг нь хоршооны нийт гишүүдийн гуравны нэгзээ доошгүй саналаар хурал зарласан байх бөгөөд уг саналд бүх гишүүдийн хурлыг хуралдуулах



үндэслэл, шалтгааныг зааж эзлжит бус хурлыг зарлахад оролцсон гишүүн бүр гарын усгээ зурсан баримт бичиг гарснаар хурлыг зарласанд тооцно.

Мен бүх гишүүдийн эзлжит бус хурлыг хуралдуулах товыг тогтоож хуралдаа хүрэлцэн ирэх боломжтой хугацааны эмне хурал зарласан саналыг бүх гишүүдэд хүргүүлсэн байвал зохино.

12.Хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь заалтын "бүх гишүүдийн хурлыг яаралтай зарлан хуралдуулна" гэдэг нь хоршооны тэргүүлэгчид үйл ажиллагаагаа явуулахгүй байна гэсэн үндэслэлээр бүх гишүүдийн хурлыг хяналтын зөвлөлөөс зарласан болон бүх гишүүдийн эзлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай гишүүдийн саналаар тавигдсан шаардлагыг биелүүлэхгүй буюу саатуулсан тэргүүлэгчид, хяналтын зөвлөлийн гишүүдийг вөрчлөх эсэх тухай асуудлыг хэлэлцэхээр бүх гишүүдийн хурал зарлан хуралдуулахгүй хэлнэ.

Энэ хурлыг хоршооны нэг буюу хэд хэдэн гишүүн зарлаж болох бөгөөд гишүүд хуралдаа хүрэлцэн ирэх боломжтой хугацаанд товыг тогтоож, тэдгээрт /бүх гишүүдэд/ зарыг хүргүүлэх буюу албан ёсоор мэдэгдсэн байх шаардлагатай.

Бүх гишүүдийн яаралтай зарлан хуралдуулсан хурал нь хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дэх заалтын дагуу хоршооны гишүүдийн дийлэнх олонх хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөр болно гэж ойлгож хэрэглэнз.

13.Хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх заалтын "Тэргүүлэгчид хоршоог төлөөлөх эрхийг тэдгээрийн олонхийн саналаар хэрэгжүүлнэ" гэдэг нь тэргүүлэгчид хоршоог төлөөлөх эрхийг хэрэгжүүлэхдээ тэргүүлэгч гишүүдийн 50.1-ээс доошгүй хувийн саналаар албан ёсны шийдвэр гаргах замаар гүйцэтгэнэ.

14.Хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2 дахь заалтын "хоршооны хөрөнгөөр төлбөр хийсн" гэдэг нь хоршооны тэргүүлэгчид нь хууль, дүрэмд заасан эрх хэмжээгээ хэтрүүлж, хоршооны хариуцвал зохих үүрэг, төлбөрт үл хамаарах зүйлд хоршооны хөрөнгөөр төлбөр хийсн байхыг хэлнэ.

15.Хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.3 дахь заалтын "хоршоог төлбөрийн чадваргүй болгосон буюу дампууруулах үндэслэл бүрдүүлсэн" гэдэгт хоршооны тэргүүлэгчдээс хууль тогтоомж, хоршооны дүрэм зөрчиж гаргасан шийдвэр, үйл ажиллагааны буруугаас хоршоонд бодитой хохирол учруулж, төлбөрийн

чадваргүй болгосон буюу дампууруулах үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд энэ явдалт тэргүүлэгч гишүүд гэм буруутай болох нь тогтоогдсон байхыг хамааруулах ба энэ нь тэргүүлэгчдэд хариуцлага тооцох үндэслэл болно.

16.Хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.4 дэх заалтын "хоршооны хөрөнгөөс зээл олгосон" гэдэгт хоршооны тэргүүлэгчид нь хууль болон тухайн хоршооны дүрэмд заасан үндэслэлгүйгээр хоршооны хөрөнгөөс, хоршооны гишүүн болон бусад этгээдэд зээл олгосон байхыг хамааруулан ойлгоо бөгөөд уг зээл эргэж төлгөдөөгүй нехцэлдээзлээр олгосон мөнгө, эд хөрөнгө болон хохирлыг тэргүүлэгч гишүүд нөхөн төлөх үндэслэл болно.

17.Хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь заалтын "Хоршоог төлөөлөх итгэмжлэл гарын үсэг зурна", мен зүйлийн 31.3 дахь заалтын "гүйцэтгэх захирлыг томилж, түүнтэй гэрээ байгуулах" эрхийг хоршооны дарга хэрэгжүүлэхдээ хоршооны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх заалт, энэ тогтооолын 13 дахь заалтын дагуу гарсан хоршооны тэргүүлэгчдийн албан ёсны шийдвэрт үндэслэнэ.

18.Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтын "хууль, дүрэмд зааснаас өөр үйл ажиллагаа явуулсан" гэдэгт хоршоо нь Хоршооны тухай хууль тогтоомж, өөрийн дүрмээр тодорхойлж улсын бүртгэлд бүртгүүлсэн зорилго, үйл ажиллагааныхаа төрлийг зөрчиж, түүнээс өөр төрлийн ажиллагаа нэг бус удаа буюу байнга эрхлэн явуулсан байхыг ойлоно.

Хоршооны эрхлэх үйл ажиллагааныхаа төрлийг вөрчлөх, түүнийг нэмэгдүүлэх ба зарим төрлийн үйл ажиллагаагаа хорогдуулах, өөр төрлийн үйл ажиллагааг явуулах тохиолдолд Хоршооны тухай хуулийн 10 дугаар зүйл заасны дагуу бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж дүрэмдээ нэмэлт, вөрчлөлт оруулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн байвал зохино.

19.Хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4 дэх заалтын "хуулийг удаа дараа буюу ноцтой зөрчсөн" гэсний "удаа дараа зөрчсөн" гэдгийг Монгол улсын хууль, тогтоомжийг хоршоо нь гурав ба түүнээс дээш зөрчснэйг, "ноцтой зөрчсөн" гэдгийг хоршоо нь эд хөрөнгөө хуурамчаар бүрдүүлсэн, түүний дүрэм, түүгээр тодорхойлсон зорилго Монгол Улсын хууль, тогтоомжид нийцээгүй, тусгай зөвшөөрөл шаардлагатай буюу хориотой үйлдвэрлэл



үйлчилгээг хууль бусаар эрхэлсэн, тайлан тэнцэл, санхүүгийн буртгэлээ санаатай будлиантуулж татвараас зайлсхийсэн, хүнсний аюулгүй байдал болон байгаль орчны аюулгүй байдлыг санаатай зөрчсөн буюу хууль, тогтоомжийт бусад хэлбэрээр зөрчсөн нь тэр, иргэд, бусад хуулийн этгээдэд их хэмжээний хохирол учруулсан ба учруулж болох байсан зэргийг ойлгох бөгөөд эдгээр нь хоршоог татан буулгах үндэслэл болж болно.

20.Хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалтын "хоршооны үйл ажиллагаа дуусгавар болсноос хойш гишүүдийн хооронд заавал нийлүүлэх хувь хөрөнгийн хэмжээ, нехех хариуцлагыг нэмэгдүүлж үл болно" гэдгийг хоршоог Хоршооны тухай хуулийн 38, 39 дүгээр зүйлд зааснаар татан буулгах тухай шийдвэр гарсан үеэс хойш гишүүдийн хоршоонд заавал нийлүүлэх хувь хөрөнгийн хэмжээ, нехех хариуцлагыг ямар нэгэн үндэслэлээр нэмэгдүүлж болохгүй гэж ойлгож хэрэглэнэ.

21.Хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь заалтын "хоршоонд нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд ийнхүү нэхэмжлэл гаргах боломжгүй нөхцөлд байгаа бол" гэдэгт татан буугджай байгаа хоршоонаас авах өр телбертэй холбоотой нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд болон түүний төлөөлөгч нь өвчилсон, байгалийн гэнэтийн аюул /гал, ус, газар хедлэлт зэрэг/ халдварт өвчний хорио цээрийн дэглэм тогтоосон, хугацаат цэргийн жинхэнэ албанад татагдсан, болон батлан хамгаалах үргээ гүйцэтгэхээр дайчлагдсан, баривчлагдан хоригдож байгаа болон ял зээлж байгаа, оршин суугаа газраасаа өөр газар удаан хугацаагаар явсан зэрээс шалтгаалан нэхэмжлэл гаргаагүй хамааруулах бөгөөд түүнд төлбел зохиц төлбөрийг төгнине.

22.Хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалтын "телберийн талаар маргаантай бол тухайн этгээдэд ногдох хэсгийг тусгаарласны дараа үлдсэн хөрөнгийг гишүүдэд хуваана" гэдгийг хоршоог татан буулгах явцад түүний харилцагчийн нэхэмжилсэн төлбөрийн талаар маргаантай бол түүнийг шүүх, арбитр шийдвэрлэх, шийдвэр нь хүчин төгөлдөр болох хүртэл тухайн этгээдийн төлбөрийг төлөхөд хүрэлцэх хэсгийг тусгаарласны дараа үлдсэн эд

хөрөнгийг гишүүдэд хуваана гэж ойлгоно.

23.Хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь заалтын "эд хөрөнгийг хуваарилахыг хориглох, эсхүл хуваарилахыг харьцааг өөрөөр тогтоож болно" гэсэн заалтыг хоршоог татан буулгахдаа харилцагч этгээдүүдийн нэхэмжлэл хангах ажиллагаа дууссаны дараа гишүүдэд уг хоршооны үлдсэн эд хөрөнгийг хуваарилахдаа хоршооны жилийн орлогос хувь хүртэх журам, заавал оруулах болон илүү оруулсан хувь хөрөнгө, хедэлмэрийн оролцоо, түүний хэлбэр /эд хөрөнгө, бэлэн мэнгэ, ажил үйлчилгээ, оюуны емч/ зэргийг харгалзан зарим гишүүнд эд хөрөнгийг хуваарилахыг хориглох буюу хуваарилахыг харьцааг хоршооны дүрмээр тухайлан тогтоосон байж болно гэж ойлгоно.

24.Хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалтын "хуваах боломжгүй үлдэгдэл мөнгө" гэдэгт: Хоршооны үйл ажиллагаа дуусгавар болоход түүний хөрөнгөнөөс үлдсэн мөнгөн болон биет байдлаар гишүүдэд хуваан олгох боломжгүй хөрөнгө болон эд хөрөнгийн эрх хамаарах бөгөөд түүнийг тодорхой зориулалтаар шилжүүлэх талаар хоршооны дүрэмд заагаагүй бол хоршооны төв оршиж байсан нийслэл, аймаг, сум дүүргийн /орон нутгийн/ өмчид шилжүүлэхийг хамааруулна.

25. Хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1.2 дахь заалтын "дүрэмд зааснаас өөр үйл ажиллагаа явуулсан бол" гэдэгт хоршоо хууль, өөрийн дүрмээр тодорхойлж, улсын бүртгэлд бүртгүүлсэн үйл ажиллагаанаас өөр үйл ажиллагаа эрхлэн явуулсан байхыг хэлнэ. Энэ тохиолдолд гэм буруутай этгээдэд шүүгээ захиргааны шийтгэл оногдуулахдаа дүрэмд зааснаас өөр үйл ажиллагааг хэдэн удаа явуулсан, байнгын шинжтэй эсэхийг үл харгалзан олсон орлогыг хурааж, хоршоог 100000-250000 төгрөг хүртэл торгоно гэж ойлгож хэрэглэнэ.

Энэ үйл ажиллагааны улмаас Хоршооны хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтын дагуу хоршоог татан буулгаж байгаа бол түүнийг татан буулгах шийдвэр гаргасан шүүх уг захиргааны шийтгэлийг оногдуулна.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ШҮҮГЧ**

**Ч.ГАНБАТ
А.ДОРЖГОТОВ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгынгазрын
Хэвлэх үйлдвэрт хэвлэв.

329487